



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/203/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: Л.Дамдинжав

Утас: 70376994 Цахим хаяг: dalaivandarkhan@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам
БШУ	Боловсрол шинжлэх ухаан

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн цэвэр нэмэлт санхүүжилтийн тайлан.....	13
3.Аудитын тайлан	14
3.1. Ерөнхий зүйл	14
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4. Материаллаг байдал.....	15
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт.....	19
4.1 Залруулсан алдаа	19
4.2 Төлбөрийн акт.....	19
4.3 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СА-2022/02-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	17,598,552.34	15,719,660.45
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
33	АВЛАГА	203,419.81	2,098.50
33500	Бусад авлага	203,419.81	2,098.50
33510	Байгууллагаас авах авлага	203,419.81	2,098.50
35	БАРАА МАТЕРИАЛ	17,395,132.53	15,717,561.95
35400	Хангамжийн материал	17,395,132.53	15,717,561.95
35410	Бичиг хэргийн материал	615,860.00	615,860.00
35420	Аж ахуйн материал	15,670,559.00	11,374,588.00
35460	Хүнсний материал	1,108,713.53	3,727,113.95
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	497,038,570.98	495,019,665.67
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	497,038,570.98	495,019,665.67
39200	Биет хөрөнгө	488,274,383.48	486,255,478.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	177,026,127.00	175,026,127.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(15,335,297.58)	(16,990,978.12)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	22,139,657.00	25,664,835.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(4,439,447.34)	(5,308,317.09)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,159,400.90	12,969,593.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(6,276,056.50)	(5,105,782.52)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	300,000,000.00	300,000,000.00
39300	Биет бус хөрөнгө	8,764,187.50	8,764,187.50
39301	Програм хангамж	225,000.00	225,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(182,812.50)	(182,812.50)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,722,000.00	8,722,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	514,637,123.32	510,739,326.12
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	514,637,123.32	510,739,326.12
51	Засгийн газрын хувь оролцоо	514,637,123.32	510,739,326.12
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	375,685,548.00	375,685,548.00
51200	Хуримтлагдсан үр дүн	38,498,364.99	34,600,567.79
51210	Өмнөх үеийн үр дүн	50,940,613.01	38,498,364.99
51220	Тайлант үеийн үр дүн	(12,442,248.02)	(3,897,797.20)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	100,453,210.33	100,453,210.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	514,637,123.32	510,739,326.12

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	279,808,872.00	273,858,935.21
11	ТАТВАРЫН ОРЛОГО		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,248,500.00	
120	Нийтлэг татварын бус орлого	5,248,500.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	5,248,500.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	274,560,372.00	273,858,935.21
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	239,519,500.00	238,283,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	239,519,500.00	238,283,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	74,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	74,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	35,040,872.00	35,501,435.21
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35,040,872.00	35,501,435.21
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	283,360,822.02	277,433,740.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	283,360,822.02	277,433,740.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	263,151,500.81	267,657,695.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	176,659,626.71	185,439,149.00
210101	Үндсэн цалин	131,814,555.95	110,917,588.00
210102	Нэмэгдэл	33,578,191.76	60,493,808.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	11,266,879.00	14,027,753.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,108,225.11	24,548,827.31
210201	Тэтгэврийн даатгал	15,233,094.79	17,371,562.21
210202	Тэтгэмжийн даатгал	1,718,496.44	1,870,278.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,446,064.30	1,486,162.96
210204	Ажилгүйдлийн даатгал	341,968.59	582,189.78
210205	Эрүүл мэндийн даатгал	3,368,600.99	3,238,633.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,654,872.00	34,674,735.21
210301	Гэрэл, цахилгаан	2,654,072.00	2,667,735.21
210302	Түлш, халаалт	32,000,800.00	32,007,000.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	0.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,666,500.00	1,417,900.00
210401	Бичиг хэрэг	80,500.00	84,500.00
210402	Тээвэр, шатахуун	217,200.00	176,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	65,200.00	568,500.00
210404	Ном, хэвлэл	58,600.00	61,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,100,000.00	374,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,145,000.00	152,100.00
2105	Нормативт зардал	9,120,654.80	7,471,799.58
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	51,300.00	53,900.00
210502	Хоол, хүнс	8,529,054.80	6,850,799.58

Сэлэнгэ аймгийн Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	540,300.00	567,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,277,000.00	1,237,800.00
210604	Урсгал засвар	2,277,000.00	1,237,800.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	86,400.00
210702	Дотоод албан томилолт	0.00	86,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,883,600.00	1,047,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	309,600.00	399,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,250,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,781,022.19	11,734,084.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,258,055.50	4,295,971.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,217,900.00	1,242,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,305,066.69	6,195,913.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,209,321.21	9,776,045.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,209,321.21	9,776,045.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,209,321.21	9,776,045.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(3,551,950.02)	(3,574,805.51)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,890,298.00	322,991.69
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	8,890,298.00	322,991.69
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(12,442,248.02)	(3,897,797.20)
VI-I	Засгийн газрын хувь оролцоо	0.00	0.00
VI-II	Хяналтын бус хувь оролцоо	0.00	0.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	274,560,372.00	273,858,935.21
11	ТАТВАРЫН ОРЛОГО		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	274,560,372.00	273,858,935.21
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	239,519,500.00	238,283,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	239,519,500.00	238,283,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		74,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		74,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	35,040,872.00	35,501,435.21
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35,040,872.00	35,501,435.21
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	269,560,372.00	273,858,935.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	269,560,372.00	273,858,935.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	249,351,050.79	264,082,890.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	176,659,626.71	185,439,149.00
210101	Үндсэн цалин	131,814,555.95	110,917,588.00
210102	Нэмэгдэл	33,578,191.76	60,493,808.00
210104	Урамшуулал	11,266,879.00	14,027,753.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,755,220.08	24,347,506.00
210201	Тэтгэврийн даатгал	14,880,089.76	17,170,240.90
210202	Тэтгэмжийн даатгал	1,718,496.44	1,870,278.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,446,064.30	1,486,162.96
210204	Ажилгүйдлийн даатгал	341,968.59	582,189.78
210205	Эрүүл мэндийн даатгал	3,368,600.99	3,238,633.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,654,872.00	34,674,735.21
210301	Гэрэл, цахилгаан	2,654,072.00	2,667,735.21
210302	Түлш, халаалт	32,000,800.00	32,007,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,666,500.00	1,417,900.00
210401	Бичиг хэрэг	80,500.00	84,500.00
210402	Тээвэр, шатахуун	217,200.00	176,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	65,200.00	568,500.00
210404	Ном, хэвлэл	58,600.00	61,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,100,000.00	374,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,145,000.00	152,100.00
2105	Нормативт зардал	7,906,332.00	10,090,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	51,300.00	53,900.00
210502	Хоол, хүнс	7,314,732.00	9,469,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	540,300.00	567,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,277,000.00	5,737,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		4,500,000.00
210604	Урсгал засвар	2,277,000.00	1,237,800.00
2107	Томилолт, зочны зардал		86,400.00
210702	Дотоод албан томилолт		86,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,883,600.00	1,047,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	309,600.00	399,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,250,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,547,900.00	1,242,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	330,000.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,217,900.00	1,242,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,209,321.21	9,776,045.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,209,321.21	9,776,045.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,209,321.21	9,776,045.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,000,000.00	
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5,000,000.00	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,000,000.00	
2200	Дотоод эх үүсвэрээр	5,000,000.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,000,000.00	
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(5,000,000.00)	
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
100	Тохируулгын орлого, зарлагын зөрүү		

2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	375,685,548.00	100,453,210.33	50,940,613.01	527,079,371.34
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	375,685,548.00	100,453,210.33	50,940,613.01	527,079,371.34
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Өмчид гарсан өөрчлөлт				
8	Зарласан ногдол ашиг				
9	Тайлант үеийн үр дүн			(12,442,248.02)	(12,442,248.02)
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	375,685,548.00	100,453,210.33	38,498,364.99	514,637,123.32
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	375,685,548.00	100,453,210.33	38,498,364.99	514,637,123.32
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	375,685,548.00	100,453,210.33	38,498,364.99	514,637,123.32
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Өмчид гарсан өөрчлөлт				
18	Зарласан ногдол ашиг				
19	Тайлант үеийн үр дүн			(3,897,797.20)	(3,897,797.20)
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	375,685,548.00	100,453,210.33	34,600,567.79	510,739,326.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	харьцуулалт
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	275,958,700.00	273,858,935.21	2,099,764.79	99.24%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	275,958,700.00	273,858,935.21	2,099,764.79	99.24%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	275,958,700.00	264,082,890.21	11,875,809.79	95.70%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	189,342,300.00	185,439,149.00	3,903,151.00	97.94%
210101	Үндсэн цалин	137,217,600.00	110,917,588.00	26,300,012.00	80.83%
210102	Нэмэгдэл	37,961,400.00	60,493,808.00	(22,532,408.00)	159.36%
210104	Урамшуулал	14,163,300.00	14,027,753.00	135,547.00	99.04%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,721,000.00	24,347,506.00	373,494.00	98.49%
210201	Тэтгэврийн даатгал	17,147,400.00	17,170,240.90	(22,840.90)	100.13%
210202	Тэтгэмжийн даатгал	1,893,400.00	1,870,278.90	23,121.10	98.78%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,514,700.00	1,486,162.96	28,537.04	98.12%
210204	Ажилгүйдлийн даатгал	378,700.00	582,189.78	(203,489.78)	153.73%
210205	Эрүүл мэндийн даатгал	3,786,800.00	3,238,633.46	548,166.54	85.52%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,848,500.00	34,674,735.21	2,173,764.79	94.10%
210301	Гэрэл, цахилгаан	4,841,500.00	2,667,735.21	2,173,764.79	55.10%
210302	Түлш, халаалт	32,007,000.00	32,007,000.00	0.00	100.00%
2104	Хангамж, бараа материалын зардал	1,417,900.00	1,417,900.00	0.00	100.00%
210401	Бичиг хэрэг	84,500.00	84,500.00	0.00	100.00%
210402	Тээвэр, шатахуун	176,400.00	176,400.00	0.00	100.00%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	568,500.00	568,500.00	0.00	100.00%
210404	Ном, хэвлэл	61,500.00	61,500.00	0.00	100.00%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	374,900.00	374,900.00	0.00	100.00%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	152,100.00	152,100.00	0.00	100.00%
2105	Нормативт зардал	15,265,600.00	10,090,200.00	5,175,400.00	66.10%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	53,900.00	53,900.00	0.00	100.00%
210502	Хоол, хүнс	14,644,600.00	9,469,200.00	5,175,400.00	64.66%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	567,100.00	567,100.00	0.00	100.00%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,737,800.00	5,737,800.00	0.00	100.00%
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,500,000.00	4,500,000.00	0.00	100.00%
210604	Урсгал засвар	1,237,800.00	1,237,800.00	0.00	100.00%
2107	Томилолт, зочны зардал	86,400.00	86,400.00	0.00	100.00%
210702	Дотоод албан томилолт	86,400.00	86,400.00	0.00	100.00%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,297,000.00	1,047,000.00	250,000.00	80.72%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	325,000.00	399,000.00	(74,000.00)	122.77%

Сэлэнгэ аймгийн Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	972,000.00	648,000.00	324,000.00	66.67%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,242,200.00	1,242,200.00	0.00	100.00%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,242,200.00	1,242,200.00	0.00	100.00%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		9,776,045.00	(9,776,045.00)	
2134	Орон нутгийн төсвийн захирагчдад олгох		9,776,045.00	(9,776,045.00)	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		9,776,045.00	(9,776,045.00)	
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	275,958,700.00	273,784,935.21	2,173,764.79	99.21%
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	238,283,500.00	238,283,500.00	0.00	100.00%
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	238,283,500.00	238,283,500.00	0.00	100.00%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	37,675,200.00	35,501,435.21	2,173,764.79	94.23%
320001	Орон нутгийн төсвөөс	37,675,200.00	35,501,435.21	2,173,764.79	94.23%
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	139.00	139.00	0.00	100.00%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.00%
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00%
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	17.00	17.00	0.00	100.00%
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00%
620002	Гүйцэтгэх ажилтан	6.00	6.00	0.00	100.00%
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00	0.00	100.00%
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	104.00	104.00	0.00	100.00%
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	104.00	104.00	0.00	100.00%
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	104.00	104.00	0.00	100.00%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	17.00	17.00	0.00	100.00%
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	17.00	17.00	0.00	100.00%

2.6 Аудит хийсэн ЦЭВЭР НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		74,000.00	-74,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		74,000.00	-74,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		74,000.00	-74,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		74,000.00	-74,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		74,000.00	-74,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		74,000.00	-74,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		74,000.00	-74,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		74,000.00	-74,000.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэгийн /Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэг гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Л.Дамдинжав, аудиторын туслах Ж.Сайнбилэг нар гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэг нь “Хүүхэд бүр өөртөө итгэлтэй, эерэг зан чанартай тууштай, суралцах сонирхолтой би хүн болгон төлөвшүүлэн” гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 283,360.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,833.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,983.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга

Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,897.8 мянган төгрөгөөр буюу 0.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	203.4	2.1	(201.3)
Бараа материал	17,395.1	15,717.5	(1,677.6)
Үндсэн хөрөнгө	497,038.6	495,019.7	(2,018.9)

Нийт хөрөнгө	514,637.1	510,739.3	(3,897.8)
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	514,637.1	510,739.3	(3,897.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	514,637.1	510,739.3	(3,897.8)

Авлага дансны үлдэгдэл 201.3 мянган төгрөгөөр буурсан нь нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлтийн авлага буурснаас шалтгаалжээ.

Бараа материал дансны үлдэгдэл 1,677.6 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 14,313.1 мянган төгрөгийн бараа материал бэлтгэн, 15,990.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 664.6 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 4,500.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 06-ний өдрийн 43 дугаар тогтоолоор 322.9 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй 5,164.6 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 510,739.3 мянган төгрөг болж 3,897.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалсан байна.

Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого өмнөх оноос 5,949.9 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө буурсан нь голлон нөлөөлжээ.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 6,016.1 мянган төгрөгөөр буюу 2.2 хувиар буурсан нь хоол, хүнсний зардал, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал буурсан нь голлон шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 295,833.0 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаа нь танхим болон танхимын бус үйл ажиллагаанд шилжүүлсэнтэй холбоотойгоор төсөвт өөрчлөлт орсон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр **275,958.7** мянган төгрөгийн төсөв баталснаас 239,110.2 мянган төгрөгийг улсын төсвөөс /тусгай зориулалтын шилжүүлгээр/, 36,848.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 238,283.5 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 35,501.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 273,784.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд **263,934.9** мянган төгрөгийг зарцуулж, төсвийн зарлагын хэмнэлтийн 9,776.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 263,934.9 мянган төгрөг буюу 96.4 хувьтай тайлагнагдсан нь цалин, НДШ-ийн зардал 4,276.6 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардал 5,175.4 мянган төгрөгөөр, аудит баталгаажуулалтын зардал 324.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд БСГ-аас ариутгал халдваргүйжүүлэлт 74.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

1. БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай ” тушаалын нэгдүгээр хавсралт “*Коронавируст халдварын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам*”-ын дагуу сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн

агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаанд нь 134 мэдээллийг бүрэн оруулсан, 15 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэгт 275,958.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 263,934.9 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 4.3 хувиар хэмнэж Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгөгдсөнөөс шилэн дансны мэдээлэлтэй холбоотой зөвлөмжийг биелүүлээгүй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	3		2		67.7
Нийт дүн	3		2		67.7

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “*Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол*” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 12,407.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 86.4 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 1,590.4 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчилд 1 төлбөрийн акт тогтоон, 10,731.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд 86.4 мянган төгрөгийн тодорхойгүй өглөг тусгасныг залруулав.

4.2 Төлбөрийн акт

1. Дээд шатны төсвийн захирагчийн тушаал шийдвэргүйгээр Ж.Сувд-Эрдэнэд 658.7 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 20.2.5 дахь “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Сахилгын шийтгэл ногдуулсан багш, албан хаагчдад сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад 931.7 мянган төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 131.4-д “*Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно*”, Засгийн газрын 2017 оны 346 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчдад улирлын ажлын үр дүнгийн урамшуулал олгох журам”-ын хавсралт 2.1-д “*Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыгбайгууллагын орчин, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, хариуцлага, ёс зүйн зөрчил гаргаагүй багш, туслах багш албан хаагчдад олгоно*” гэж заасныг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байгаа албан хаагчид олгосон улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1.1 Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.1.1 Илрүүлэлт: Тайлант онд 9,469.2 мянган төгрөгийн хүнсний материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх

1.2 Цалингийн данстай холбоотой асуудал

1.3.1 Илрүүлэлт: НД тайланд арга зүйч О.Бямбацэцэгийн цалинг 1,261.8 мянган төгрөгөөр илүү тайлагнаж, байгууллагаас 303.0 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн байна.

1.3.2 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчиж байгаа тул НД-ын тайланг илгээхдээ дахин хянаж баталгаажуулах байх.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэг	5	12,407.8	1	86.4	2	1,590.4	1		2	10,731.0

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.